

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2018.02.09

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 110 хуулийн 544 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын 77 хуулийн 196 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 хууль буюу 40.0 хувь, 127 хэсэг, заалт буюу 23.3 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 33 хуулийн 69 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтаас хассан хуулиуд байсан бөгөөд хяналтанд авсан 33 хуулийн 348 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй болно.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	110	544
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	77	196
	- Хяналтанд байгаа	44	127
	- Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	33	69
3	Засгийн газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	33	348

Хяналтанд байгаа хуулийн хэрэгжилтийг авч үзвэл, давхардсан тоогоор 14 хуулийн 21 хэсэг, заалт буюу 16.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 17 хуулийн 30 хэсэг, заалт буюу 23.6 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 16 хуулийн 51 хэсэг, заалт буюу 40.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 10 хуулийн 14 хэсэг, заалт буюу 11 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 11 хэсэг, заалт буюу 8.7 хувь нь хугацаа болоогүй байна¹.

2.2. Монгол Улсын хуулиар Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 12 хуулийн 107 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 11 хуулийн 14 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 4 хуулийн 6 хэсэг, заалт буюу 42.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 4 хуулийн 4 хэсэг, заалт буюу 28.6 хувь нь хэрэгжих шатандаа, 1 хуулийн 1 заалт буюу 7.1 хувь нь хугацаа болоогүй, 2 хуулийн 2 хэсэг, заалт буюу 14.3 хувь нь үнэлээгүй, 1 хуулийн 1 заалт буюу 7.1 хувь нь хэрэгжээгүй байна.

	Хууль	Хэсэг, заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
Хяналтанд авсан	12	107	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	11	14	
Үүнээс:			
- бүрэн хэрэгжсэн	4	6	42.9
- хэрэгжих шатандаа	4	4	28.6
- хугацаа болоогүй	1	1	7.1
- үнэлээгүй	2	2	14.3
- хэрэгжээгүй	1	1	7.1

2.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасан “Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэх зааврыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэсэн заалтын хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай ирүүлж байсан бол 2017 оны хагас жилийн байдлаар 30 хувийн хэрэгжилттэй гэж ирүүлэн хэрэгжилтийн хувийг бууруулсан байна.

¹ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү журмын 6.3-т заасны дагуу хэрэгжилтийг тооцсон болно.

2. Хяналтанд байгаа хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн заалтууд:

- 2015.05.29-ны өдрийн Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7, 30 дугаар зүйлийн 30.3, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэг;
- 2015.06.19-ны өдрийн Захиргааны ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсэг;
- 2015.07.02-ны өдрийн Галын аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 10 дугаар зүйлийн 10.4, 14 дүгээр зүйлийн 14.3, 18 дугаар зүйлийн 18.4, 18.7, 19 дүгээр зүйлийн 19.9, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг;
- 2015.07.08-ны өдрийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг;
- 2015.07.08-ны өдрийн Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг;
- 2015.06.19-ний өдрийн Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг;
- 2017 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн мэдээг тус тус ирүүлээгүй байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын нийт 63 тогтоолын 179 заалтыг мэдээллийн сандаа бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын нийт 44 тогтоолын 105 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 23 тогтоолын 37 заалт буюу 35.2 хувь нь бүрэн хэрэгжсэн, 27 тогтоолын 52 заалт буюу 49.6 хувь нь хэрэгжих шатанд, 6 тогтоолын 12 заалт буюу 11.4 хувь нь хэрэгжээгүй, 4 тогтоолын 4 заалт буюу 3.8 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 5 тогтоолын 10 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын нийт 2 тогтоолын 2 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг авч үзвэл 1 тогтоолын 1 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжээгүй байна.

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	5	10	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	2	2	
Үүнээс:			
- Хэрэгжих шатанд	1	1	50.0
- Хэрэгжээгүй	1	1	50.0

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 94 тогтоолын 719 заалтыг хяналтанд авснаас 185 заалт хэрэгжиж хяналтаас хасагдаж 534 заалт хяналтад үлдсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны хагас жилийн байдлаар 37 тогтоолын 159 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Эдгээр 37 тогтоолын 159 заалтаас 22 тогтоолын 41 заалт буюу 25.8 хувь нь хэрэгжсэн, 27 тогтоолын 99 заалт буюу 62.3 хувь нь хэрэгжих шатанд, 11 тогтоолын 18 заалт буюу 11.3 хувь нь хэрэгжээгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.6 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

4.2. Хууль зүйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Хууль зүйн байнгын хорооны 7 тогтоолын 48 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Хууль зүйн байнгын хорооны 4 тогтоолын 23 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 3 тогтоолын 10 заалт буюу 35.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 тогтоолын 10 заалт буюу 58.8 хувь нь хэрэгжих шатандаа, 2 тогтоолын 3 заалт буюу 5.9 хувь нь хэрэгжээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ХЗБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	7	48	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	4	23	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	3	10	43.5

- Хэрэгжих шатанд	2	10	43.5
- Хэрэгжээгүй	2	3	13.0

4.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Хууль зүйн байнгын хорооны

-“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай /2016.11.16 №10/ Байнгын хорооны тогтоолын 1.3-т заасан “Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн төрөлжсөн асрамжийн газар байгуулах хөрөнгө, санхүүжилтийг судлан шийдвэрлэх”;

-“Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2011 оны .. тогтоолын 1 дэх хэсэгт заасан “Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахим хэлбэрт шилжүүлэх (тоон гарын үсгийн хэрэглээг нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах, төрийн болон төсөвт байгууллагыг техник хэрэгслээр хангах, холбогдох дүрэм, журмыг боловсруулах, мэдээллийг кодлох, цахим мэдээллийн сан бүрдүүлэх болон бусад арга хэмжээг хамааруулсан) төлөвлөгөөг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлэх”, 2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүрд тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох нөхцөлтөйгөөр иргэний ухаалаг үнэмлэхэд суурилуулан олгож, уг арга хэмжээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх” гэсэн заалтууд хэрэгжээгүй байна.

2. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай” /2013.01.16 №02/ Байнгын хорооны тогтоолын бүх заалтын хэрэгжилт 2016 оны жилийн эцсийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтай ирж байсан бол 2017 оны хагас жилийн мэдээнд 2; 6; 7 дахь заалтуудын хэрэгжилтийн мэдээг дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ.

Хяналтанд байгаа нийт тогтоолын талаас илүү хувийх нь хэрэгжилтийн мэдээг Засгийн газраас ирүүлээгүй байна. Тухайлбал,

- 2010 онд батлагдсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолын 9 заалт;
- 2012 онд батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай” 01/21 дүгээр тогтоолын 3 заалт;
- 2015 онд батлагдсан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоолын 9 заалт;
- 2015 онд батлагдсан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 4а, 4ж заалтууд.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн дараах хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

Монгол Улсын 4 хуулийн 6 заалт, Хууль зүйн байнгын хорооны 3 тогтоолын 8 заалтын мэдээг ирүүлсэн байна.

Хууль тогтоомж	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо
Монгол Улсын хууль	4	6
Байнгын хорооны тогтоол	3	8

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийж, үнэлээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тайлбарлаагүй, хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2016 онд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлэх, мэдээллийн санг шинэчлэхгүй байх, өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулан дахин ирүүлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байх зэрэг дутагдалдаа дүгнэлт хийж ажиллах нь зүйтэй байна.

4/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлэхэд хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

5/ Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2017 оны хагас жилийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай 2015-07-08	24.2.Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэх заавар”-ыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай хамтран боловсруулж, Хууль зүйн болон Эрүүл мэндийн сайдын 2016 оны 4 дүгээр 25-ны өдрийн А/131/138 дугаар хамтарсан тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.
		4.2.Замын хөдөлгөөний дүрмийг Засгийн газар батална.	“Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
2	Захиргааны ерөнхий хууль 2015-06-19	54.4.Энэ хуулийн 54.2, 54.3-т заасан гэрээг хянаж, бүртгэхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.	Захиргааны ерөнхий хуулийн 54.4, Олон улсын гэрээний тухай хуулийн 4.4-т заасныг үндэслэн “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор батлав. Энэ оны эхний хагаст байгууллага хоорондын 83-н гэрээг хянаж холбогдох зөвшөөрөл өгөх, санал дүгнэлт гаргах, орчуулгыг хянаж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэв.
3	Хууль тогтоомжийн тухай /шинэчилсэн найруулга/ 2015-05-29	49.1.Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна.	Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-аар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн тайлан мэдээллийг нэгтгэн, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг УИХ, ЕТГ, Засгийн газарт танилцуулах ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган ажиллах ажлыг ЗГХЭГазар хариуцан ажиллаж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар, яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, хариуцан ажиллаж байна.

		<p>52.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, хууль тогтоомжийг системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p>	<p>Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу тус яамны толгойлон хэрэгжүүлэх хууль тогтоомжийн 2016 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн Захиргааны ерөнхий хуулийн 72.1-д заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан болгохтой холбогдуулан авах арга хэмжээний талаар 2016.08.17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж 41 дүгээр тэмдэглэл гарсан. Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн болно.</p> <p>Хууль тогтоомжийн кодификаци хийх хүрээнд тус яамнаас Улсын Их Хурал, Засгийн газраас ирүүлсэн хууль тогтоомжийн /цаасан/ эх хувийг эрхлэн хөтөлж хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр эх хувьд тусган кодификаци хийж сан бүрдүүлэн ажиллаж байна.</p>
4	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай 2012-05-22	<p>15.2.Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>Сангийн сайдын 2015.05.06-ны өдрийн 65/110 тоот "Журам батлах тухай" тушаалаар иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг баталсан.</p>
<p>Нийт 4 хуулийн 6 хэсэг, заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2016.11.16 №10	<p>2.2.Өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлт, гомдлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шалган шийдвэрлэдэг байх, мөн хэрэг хянан шийдвэрлэх явцад өмгөөлөгчийн гаргасан нотлох баримтыг үнэлдэг байх зарчмыг холбогдох хуульд тусган шийдвэрлүүлэх;</p> <p>2.3.Шүүгдэгчийн цагдан хорих хугацааг олон улсын хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн холбогдох хуульд тусган шийдвэрлүүлэх;</p> <p>2.5.Цагдан хорих байранд хүний эрхийн зарчим, стандартын дагуу хориг хязгаарлалтгүй, ганцаарчлан үйлчлүүлэгчтэйгээ уулзах нөхцөлийг өмгөөлөгчид бүрдүүлж өгөх;</p> <p>3.1.Ахмад настны нийгмийн амьдралд оролцох эрхийн хамгаалалт болон тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуульд тусган шийдвэрлүүлэх;</p>	<p>2017 оны 5 сарын 18-ны өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмгөөлөгч санал, хүсэлт, гомдол гаргах эрхтэй, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлт, гомдлыг мөрдөгч, прокурор, шүүгч хүлээн авч шалган шийдвэрлэж, хариу өгөх, мөн өмгөөлөгчийн гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч хүлээн авч, тэмдэглэл үйлдэн хавтаст хэрэгт тусгаж хавсаргахаар, гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг өмгөөлөгчийн хүсэлтээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр нотлох баримтаар тооцуулах, шүүх хуралдаанд шинжлэн судлуулах эрхтэй байхаар тус тус тусгасан.</p> <p>2017 оны 5 сарын 18-ны өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагчийг /шүүгдэгч/ цагдан хорих үндсэн хугацаа 2 сар хүртэл байсныг 1 сар болгож, дээд талын хугацаа 24 сар байсныг богиносгож, 18 сар болгож тусгасан.</p> <p>Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 17.1.4-д “Хоригдсон этгээд өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй”, 19.1-д “Хоригдсон этгээд нь хорих байранд өөрийн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзаж болно” гэсэн заалтын дагуу цагдан хорих байранд хоригдсон этгээдийг өмгөөлөгчтэй нь ямар нэгэн хориг хязгаарлалтгүй, ганцаарчлан уулзах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Цагдан хорих байранд өмгөөлөгч цагдан хоригдсон яллагдагчтай ганцаарчлан уулзах өрөө нь харилцааны нууцлалыг хангасан байна.</p> <p>Монгол Улсын Их Хурал 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан Ахмад настны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д Монгол Улсын иргэн 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэйчүүдийн эрхийг хангах, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх болон энэ талаар аж ахуйн нэгж, байгууллагуудын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон. Мөн энэ хуульд ахмад настнуудын нийгмийн хамгааллын асуудлаас гадна ахмад настны эрхийг хангахад төрөөс баримтлах зарчим, ахмад настанд шинэ төрлийн үйлчилгээнүүд үзүүлэх, тэдний хөгжил, оролцоог дэмжих, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг эрхийн асуудлыг шинээр тусгаж, хөдөлмөрлөх эрхийг</p>

			<p>баталгаажуулах арга хэмжээг тодорхойлон зааж өгсөн.</p> <p>Түүнчлэн гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь ахмад настныг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд оролцоход нь саад учруулах, хязгаарлах, асран сувилах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийхийг хориглох, мөн ахмад настны өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тэтгэвэр, тэтгэмж, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалахыг хориглох зэрэг заалтуудыг тусгасан.</p>
2	<p>“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээн НББСШУБХ-ны 2015.10.01 №28</p>	<p>10.эрүүдэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудлын хүрээнд хууль сахиулагчид болон хуульчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүний эрхийн чиглэлээр тогтмол сургалтад хамруулах</p>	<p>ХЗДХЯам Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу хүний эрхийн чиглэлээр Хүний эрхийн үндэсний комисстой хамтран холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалтад хамруулах, зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал: Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Олон улсын хүний эрхийн гэрээний тайлан, илтгэл боловсруулах нь” зөвлөгөөн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион явуулсан “Хүний эрхийг хамгаалах”, Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Жендэр ба хүний эрх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ”, “Хуулийн шүүмж”, Хууль зүйн, үндэсний хүрээлэн, “Гал голомт” төрийн бус байгууллагаас хамтран зохион байгуулсан “Хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх нь”, “Жендер, хүний эрх ба хувийн нууц”, Улаан загалмайн нийгэмлэгээс зохион байгуулсан “Жендэр тэгш эрх” сэдэвт сургалтуудад нийт 142 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хянагч, шийдвэр гүйцэтгэгч болон бусад алба хаагч нарыг хамруулаад байна.</p> <p>Түүнчлэн цагдаагийн байгууллагаас “Хүний эрхийн тухай ойлголт, түгээмэл тунхаглал”, “Хүний эрх ба эрүүдэн шүүхийн эсрэг”, “Зөрчлийг шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг нотлох ажиллагааны онол парктикийн зарим асуудал”, “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэх нь” сэдэвт сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж 61 алба хаагчийг хамруулсан.</p> <p>Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл болон эрүүгийн хэргийн дэлгэрэнгүй судалгааг улирал бүр Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлэн ажиллаж байна.</p>
3	<p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай. 2013-01-16</p>	<p>2.Баривчлах, ял эдлүүлэх байрыг шинээр барих асуудлыг шийдвэрлэх</p>	<p>2013, 2014 онд: Булган, Орхон, Увс аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албадад цагдан хорих байрны барилгыг ашиглалтад оруулсан.</p> <p>2015 онд: Говь-Алтай, Дорнод, Дундговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албанд “Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр”-ны барилгыг ашиглалтад оруулсан.</p> <p>2016 онд: Архангай, Баянхонгор, Завхан аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албад болон Сэлэнгэ</p>

		<p>аймгийн Сайхан сум дахь Шийдвэр гүйцэтгэх хэсэгт “Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр”-ны барилгыг ашиглалтад оруулсан.</p> <p>2017 онд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Хорих 401 дүгээр хорих анги-Нэгдсэн эмнэлгийн “Нэг цонхны үйлчилгээ бүхий шалган нэвтрүүлэх байр”; 2.Хорих 407 дугаар ангийн “Нэг цонхны үйлчилгээ бүхий шалган нэвтрүүлэх байр”; 3.Ховд аймаг дахь ШГА- Хорих 457 дугаар ангийн “Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр”; 4. Хэнтий аймаг дахь ШГА- Хорих 419 дүгээр ангийн “Нэг цонхны үйлчилгээ бүхий шалган нэвтрүүлэх байр”-ны барилгын явагдаж байна. <p>Мөн УИХ-аас 2015.12.05-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн ялын төрлөөс баривчлах ял хасагдсан байна.</p>
	<p>6.Хоригдлуудад зориулсан нийгэмшүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах тусгай өрөө тасалгаа бий болгох.</p>	<p>Нийт хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад ял эдлэгсдэд зориулсан нийгэмшүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах тусгай өрөө танхимыг бий болгон орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр удирдлага зохион байгуулалтаар тогтмол ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд нийт хорих анги, албадаас бясалгалын өрөөтэй 25, үзвэрийн өрөө болон видео сургалтын өрөөтэй 7, сургалтын танхимтай 24, соёл урлагийн танхимтай 9, номын сантай 25 хорих анги үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Дорнод, Дорноговь, Дундговь аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албадууд бясалгалын өрөөг шинээр тохижуулан ял эдлэгсдийг нийгэмшүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Дээрх тусгай өрөө танхимыг тохижуулан алжаал тайлах болон тархи амраах аппарат, буйдан, сандал, CD тоглуулагч хөгжим, дэлгэц зэрэг тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна.</p>
	<p>7.Төрийн байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эмэгтэй албан хаагчийн хувьд ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг төрөл бүрийн дарамт учруулахаас урьдчилан сэргийлэх, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх чиглэлээр анхаарч ажиллах.</p>	<p>Цагдаагийн алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд төр, байгууллага, хувь хүний нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тэдгээрт холбогдох хууль тогтоомж зөрчих, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, судалгаа хийх, холбогдох гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлүүлэх зэргээр байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах болон тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар тооцоо, судалгааг гаргаж Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд тусгуулан батлуулсан. Мөн Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай уялдуулан цагдаагийн байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах талаар цагдаагийн байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж баталж, мөрдөн ажиллаж байна. Тухайлбал Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 922-д “Ялгаварлан гадуурхах, ажлын байрны бэлгийн дарамтаас хамгаалах” талаар шинээр нэмж тусгасан. Цагдаагийн байгууллагын 2017 онд дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 7 зүйл, 49 заалттайгаар боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн цагдаагийн алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг байгуулан үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган</p>

			<p>харилцан мэдээ, мэдээлэл солилцон ажиллаж байна. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 25 зөвлөмж хүргүүлж, үр дүнг тооцож байна. Энэ оны эхний 5 сарын байдлаар 25 алба хаагч эрүүгийн 12 гэмт хэрэгт өртөж, 70 алба хаагч 70 захиргааны зөрчилд тус тус өртөж хохирсон байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал гэмт хэргийн тоо 3 буюу 33.3 хувиар, алба хаагч 16 нэгжээр, захиргааны зөрчил 11 буюу 18.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>ШШГЕГ-ын даргын 2017.03.10-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар ШШГБ-ын алба хаагчдын аюулгүй байдлын мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “ШШГБ-ын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг баталж, хуваарийн дагуу нийт хорих анги, байгууллагын алба хаагчдад сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Алба хаагчийн аюулгүй байдал, албаны хэвийн ажиллагаанд хяналт тавих зорилгоор хорих анги, байгууллагын шалган нэвтрүүлэх байр, холбоо хяналтын өрөө, ялтны байр, хонгил, гадна талбайн хяналтын камерт тус газрын Шуурхай удирдлага, хяналтын төвөөс хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Ялтны амьдралын бүсэд байрладаг сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, сувилагч нарын албан өрөөнд телекамер суурилуулсан нь аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжтой болсон.</p> <p>Хорих байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын үр дүнг тооцох, ялтан, хоригдогч нарт биечлэн хяналт тавьж буй хянагч нарын үүрэг гүйцэтгэлд тулгарч буй хүндрэл бэрхшээл, ажлын ачааллыг бодитойгоор тогтоон, цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлох зорилгоор 24 асуулт бүхий 12 хорих анги, 22 шийдвэр гүйцэтгэх албаны 876 алба хаагчаас судалгаа авсан.</p>
<p>Нийт 3 тогтоолын 8 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			